



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 68

Есөнбулаг сум

Хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сургалтын чанарыг ахиулах” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 27 дугаар сарын
24 өдрийн 27 дугаар тогтоолын хавсралт



**“СУРГАЛТЫН ЧАНАРЫГ АХИУЛАХ” ХӨТӨЛБӨР
/2017-2020/**

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Өнөөгийн нийгэмд өндөр мэдлэгтэй, аль ч орчинд дасан зохицох чадвартай, ёс суртахуун хүмүүжил төлөвшилтэй, багаар ажиллах чадвартай иргэнийг дэлхий нийтээрээ хүсэж байна.

2014-2016 онд улс, бүсийн хэмжээний олимпиад уралдаанд 8 багш алт, 16 багш мөнгө, 10 багш хүрэл медаль, 21 сурагч алт, 24 сурагч мөнгө, 32 сурагч хүрэл медаль хүртэж түүх нийгмийн ухааны багш, сурагчдын баг улсад дэд байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн.

Говь-Алтай аймгийн сургалтын чанарт дүн шинжилгээ хийж үзэхэд багш сурагчдын ганцаарчилсан амжилт дээгүүр үзүүлэлттэй гарсан нь хүүхэд бүрийг хөгжүүлэх нөөц боломж байгааг харуулж байна.

Сургууль, багшийн өөрийн үнэлгээгээр сургалтын чанарын үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн боловч Элсэлтийн ерөнхий шалгалтын нэгдсэн дүн улсын дунджаас доогуур, 2015-2016 онд хэрэгжсэн “Сургалтын чанарыг сайжруулах” дэд хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээний дундаж үзүүлэлт хангалтгүй байгаа нь хөндлөнгийн хяналт үнэлгээг тогтмол хийж байх шаардлагатайг харуулж байна.

Мөн ЭЕШ-ын үнэлгээ доогуур байгаа нь сургуулиудын бүтэц, хэв шинж оновчгүй байгаатай холбоотой.

Сургалтын байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагаа, хариуцлага, идэвх оролцоо, хандлагыг бодлогын түвшинд тусгаж хэрэгжүүлээгүйгээс хөндлөнгийн хяналт суларсан нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

2015-2016 оны “Сургалтын чанарыг сайжруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд сургууль, судлагдахуун бүрээр хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний аймгийн дундаж гүйцэтгэл 47%-тай, мөн ЭЕШ-ын үнэлгээ хөтөлбөр хэрэгжсэн хугацааны өмнөх жилээс 7 байр ахисан, 5-р ангийн сурагчдаас авсан 2 жилийн хөндлөнгийн үнэлгээний дундаж 10.8%-иар ахисан зэрэг үзүүлэлтийг доорх хүснэгтээр харууллаа.

Д/д	Судлагдахуун	ЭЕШ-ын улсын дундаж	ЭЕШ-ын 2015 оны дундаж гүйцэтгэл	ЭЕШ-ын 2016 оны дундаж гүйцэтгэл	ЭЕШ-ын 2017 оны дундаж гүйцэтгэл	2015-2016 оны аймгийн хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэл
1.	Математик	500=62.5%	480.6=60%	496=62%		41%
2.	Монгол хэл	500=62.5%	513.9=64.2%	524=65.5%		63%
3.	Нийгэм	500=62.5%	494.6=61.8%	512=64%		48%
4.	Англи хэл	500=62.5%	485.6=60.7%	475=59.3%		39%
5.	Орос хэл	511=63.8%	479.3=59.9%	456=57%		56%
6.	Газар зүй	500=62.5%	502.8=62.8%	511=63.8%		38%
7.	Физик	500=62.5%	491.4=61.4%	490=61.2%		34%
8.	Хими	500=62.5%	466.7=58.3%	488=61%		49%
9.	Биологи	500=62.5%	462.8=57.8%	492=61.5%		43%
10.	МУ-ын түүх	500=62.5%	502.8=62.8	547=68.3%		
11.	Монгол хэл бичиг	499=62.3%		406=50.7%		
12.	Мэдээллийн технологи					40%
13.	Дизайн технологи					39%
14.	Дүрслэх урлаг					46%

15.	Биеийн тамир					65%
16.	Хөгжим					46%
	Нэгдсэн дундаж гүйцэтгэл	62.5	60.9%	61.3%		47
	ЭЕШ-ын улсад эзэлсэн байр		17-р байр	11-р байр		
	5-р ангийн хөндлөнгийн үнэлгээний үзүүлэлт		45.6%	56.4%		

Үүнээс үзэхэд хүүхэд бүрийг амжилттай сургах, хөгжүүлэх, төлөвшүүлэх, бага суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалтын дүн улс, бүсийн уралдаан тэмцээний үзүүлэлт, оролцоог нэмэгдүүлэх, өдөр тутмын сургалтын үйл ажиллагааг чанаржуулах шаардлагатай байгаа нь хөтөлбөрийг сайжруулан үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Сургалтын байгууллагын хэв шинж, менежментийг боловсронгуй болгож, эцэг эх, хүүхэд, багш нарын багаар ажиллах, хамтын ажиллагааг сайжруулан, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлж, хүүхэд бүрийг амжилттай сургах, сурах эрмэлзэл, сэтгэлзүйн зөв чиг хандлагыг төлөвшүүлж, сургалтын чанарт ахиц гаргана.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

3.1. Суралцагчийн идэвх оролцоог нэмэгдүүлж хөгжил, төлөвшилд эерэг хандлага бий болгоно.

3.2. Суралцагч бүрийн хөгжил төлөвшилд, эцэг эхийн оролцоо хандлагыг нэмэгдүүлнэ.

3.3. Хүүхэд бүрд ээлтэй сургалтын орчин бүрдүүлнэ.

3.4. Сургалтын чанарыг бодитоор үнэлэн ахиц амжилт гаргасан баг, хамт олныг урамшуулах ажлыг үе шаттай үр дүнтэй зохион байгуулна.

3.5. Сургуулиудын хэв шинж, менежментийг боловсронгуй болгоно.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Суралцагчийн идэвх оролцоог нэмэгдүүлж хөгжил, төлөвшилд эерэг хандлага бий болгох.

4.1.1. Суралцагчийн эрх, үүргийг хүүхэд бүрт ойлгуулан таниулж, суралцах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлнэ.

4.1.2. Хүүхэд бүрийн өөртөө итгэх итгэл, манлайллыг нэмэгдүүлнэ.

4.2. Суралцагч бүрийн хөгжил төлөвшилд, эцэг эхийн оролцоо хандлагыг нэмэгдүүлэх.

4.2.1. Сургууль, эцэг эх, багш, сурагчдын хамтын ажиллагааг сайжруулна.

4.2.2. Багш бүрийн зааж буй ээлжит хичээл болгонд эцэг, эхийн төлөөллийг оролцуулж хэвшинэ.

4.2.3. Төрийн болон төрийн бус байгууллагуудын хүүхдэд ээлтэй үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

4.3. Хүүхэд бүрт ээлтэй сургалтын орчинг бүрдүүлэх.

4.3.1. Хүүхдэд ээлтэй материаллаг орчныг бүрдүүлнэ.

4.3.2. Хүүхдэд ээлтэй ЭКО орчин бүрдүүлнэ.

4.4. Сургалтын чанарыг ахиулах, бодитой үнэлэх ахиц амжилт гаргасан баг, хамт олныг урамшуулах ажлыг үе шаттай, үр дүнтэй зохион байгуулах.

4.4.1. Сургалтын чанарыг ахиулах хөндлөнгийн хяналт үнэлгээг зохион байгуулна.

4.4.2. ЭЕШ-ын амжилт, үзүүлэлтийг ахиулна.

4.4.3. ЭЭШ болон хөндлөнгийн үнэлгээний үзүүлэлтээр амжилт гаргасан багш, сургууль, ЗАН-ийн баг хамт олныг үнэлж урамшуулан, хариуцлага тооцно.

4.5. Сургуулиудын хэв шинж, менежментийг боловсронгуй болгох.

4.5.1. Есөнбулаг сумын хэмжээнд сургуулийн хэв шинжийг сайжруулж, хамран сургах тойрог болон анги дүүргэлтийн тушаал, журмыг хэрэгжүүлж ажиллана.

4.5.2. Хөдөө орон нутгийн сургуулиудын нөөц боломжид суурилсан бүсийн ахлах сургуулийг бий болгоно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1.Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах хөтөлбөрийн үе шат бүрийн төлөвлөлт хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажиллана.

5.2. Хөтөлбөрийг аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сурагч, эцэг эх, эцэг эхийн зөвлөлөөс бүрдсэн ажлын хэсгийг аймаг, сумдад байгуулж ажлын хэсгүүд нь удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

5.3.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, төлөвлөгөөг Боловсрол, соёл урлагийн газар боловсруулна.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжих үе шат

6.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөр нь дараах үе шатаар хэрэгжинэ.

6.2.1. Хүүхэд бүрийн сурах арга барилыг хөгжүүлэх, сургалтын байгуул-лагын менежмент, хэв шинжийг шинэчлэх, үнэлгээний арга зүйг тодорхойлох, эцэг эхийн оролцоо хандлагыг сайжруулах үе \2017-2018 он\

6.2.2. Хүүхэд бүрд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх үе \2018-2019 он\

6.2.3. Хөтөлбөр хэрэгжсэнээр сургалтын чанарт гарсан ахицыг баталгаа-жуулах үе \2019-2020 он\

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Улс, орон нутгийн төсөв. ,

7.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, дэмжлэг, тусламж.

Найм. Дээрх зорилтын хүрээнд хийгдэх ажлуудын нарийвчилсан төлөвлөгөө болон үнэлж урамшуулах, шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргана.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллага, олон нийтийн үүрэг, оролцоо, хамтын ажиллагаа

9.1. Боловсрол, соёл, урлагийн газар:

9.1.1. Сургалтын чанарыг ахиулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

9.1.2. Судалгаанд суурилсан мэргэжлийн удирдлагаар ханган, мэргэжил арга зүйн талаар зөвлөн тусална.

9.1.3. Сурлагын ахиц амжилтыг бодитоор үнэлж, урамшуулах ажлыг чанартай зохион байгуулна.

9.1.4. Хөндлөнгийн үнэлгээний жишиг даалгаврыг сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, агуулгын хүрээнд үндэслэн алдаагүй боловсруулж, гүйцэтгэлийг бодитой гарган ажиллана.

9.2. Ерөнхий боловсролын сургууль:

9.2.1. Сургалтын чанарыг ахиулах дэд хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг сургууль, удирдах ажилтан ажилчид, багш сурагч, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган үр дүнг улирал, жилээр тооцон тайлагнаж ажиллана.

9.2.2. Сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллана.

9.2.3. Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эхийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хүүхэд бүрийн хөгжил төлөвшлийн ахиц амжилтад хувь нэмрээ оруулан, хамтран ажиллах, харилцаа холбоог бэхжүүлэх, ажлыг үр дүнтэй тогтмол зохион байгуулах боломжийг бүрдүүлнэ.

9.3. Аймаг, сумдын Засаг дарга:

9.3.1. Хүүхэд бүрийн ахиц амжилт, хөгжлийн төлөө Боловсрол соёл, урлагийн газар болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг бүхий л талаар дэмжиж, багш, эцэг эх, хүүхэд бүрт гарсан ололт амжилтыг бодитоор үнэлж урамшуулна.

9.3.2. Орон нутгийн төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, эцэг эхийн төлөөлөл сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож, суралцагчдын хөгжил төлөвшлийн ахиц амжилтыг тайлагнах, хамтран ажиллах, харилцаа холбоог бэхжүүлэх ажлыг үр дүнтэй тогтмол зохион байгуулахад удирдлагаар хангаж оролцоно.

9.4. Эцэг эх, олон нийт:

9.4.1. Хүүхэд бүрийн хөгжил, төлөвшлийн төлөө боловсролын үйл ажиллагааг дэмжиж оролцоно.

9.4.2. Хүүхдийг зөв хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, боловсрол эзэмшүүлэхэд эцэг эх олон нийт хамтран оролцож, дэмжин, хяналт тавина.

9.4.3. Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хамт олон, хүүхдийн болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэдийн дэмжлэг тусалцааг авч, хамтран ажиллана.

9.4.4. Хүүхдэд журамт үүргээ биелүүлэхэд нь тусална.

9.5. Хэвлэл мэдээллийн байгууллага.

9.5.1. Хүүхдийн хөгжил, төлөвшил, боловсролын талаар баримталж буй бодлого, зохион байгуулсан арга хэмжээг сурталчлан мэдээлнэ.

9.5.2. Суралцагчдын боловсролын чиглэлээр олон нийтийн хэрэгцээ, дуу хоолой, санал бодлыг хэвлэл мэдээллээр дамжуулан холбогдох байгууллагад хүргэх, асуудал дэвшүүлнэ.

9.5.3. Сурагч, эцэг эхэд зориулсан нэвтрүүлэг, булан, цагийг бий болгон боловсролын байгууллагуудтай хамтран ажиллана.

9.5.4. Шилдэг үйл ажиллагаа, арга туршлагатай ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургууль, анги хамт олон, багш, эцэг эхийг алдаршуулан таниулна.

Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, үр дүн

10.1. Тоон үнэлгээний шалгуур үзүүлэлт:

10.1.1. Судлагдахуун бүрийн хөндлөнгийн үнэлгээний аймгийн дундаж үзүүлэлтийн шалгуур, хүрэх үр дүн

Д/д	Судлагдахуун	Одоогийн түвшин /2016-2017 он/	Явцын түвшин /2018-2019 он/	Хүрэх түвшин /2019-2020 он/
1.	Бага анги	53%	56%	60%
2.	Математик	41%	44%	50%
3.	Физик	34%	43%	50%
4.	Мэдээллийн технологи	40%	44%	50%
5.	Хими	49%	52%	55%

6.	Биологи	43%	46%	52%
7.	Түүх нийгмийн ухаан	48%	54%	60%
8.	Газар зүй	38%	45%	50%
9.	Монгол хэл	63%	65%	68%
10.	Дизайн технологи	39%	45%	50%
11.	Дүрслэх урлаг	46%	50%	55%
12.	Биеийн тамир	65%	68%	70%
13.	Хөгжим	46%	50%	53%
14.	Англи хэл	39%	42%	50%
15.	Орос хэл	56%	59%	62%
	Ерөнхий дундаж	47%	54%	59%

10.1.2. Сургуулиудын хөндлөнгийн үнэлгээний дундаж үзүүлэлтийн шалгуур, хүрэх үр дүн:

Д/д	Сургуулийн нэр	Одоогийн түвшин 2015-2016 он	Явцын түвшин 2018-2019 он	Хүрэх түвшин 2019-2020 он
1.	Гуулин	63%	65%	68%
2.	ХЭЦ сургууль	56%	60%	63%
3.	Оюуны түлхүүр	55%	58%	62%
4.	Шарга	52%	55%	60%
5.	1-р сургууль	52%	55%	60%
6.	Тахийн тал	50%	53%	58%
7.	Тайшир	50%	55%	60%
8.	2-р сургууль	49%	55%	60%
9.	Дэлгэр	48%	54%	59%
10.	Халиун	48%	55%	60%
11.	Жаргалан	47%	54%	60%
12.	Цээл	47%	54%	60%
13.	Алтай	47%	54%	60%
14.	Тонхил	46%	54%	60%
15.	Алтансоёмбо	46%	54%	60%
16.	Бигэр	46%	54%	60%
17.	3-р сургууль	46%	54%	60%
18.	Баянтоорой	45%	53%	60%
19.	Дарив	45%	50%	55%
20.	Хөхморьт	45%	50%	55%
21.	Баян-Уул	44%	50%	55%
22.	Чандмань	44%	50%	55%
23.	Бугат	43%	50%	55%
24.	Лицей	41%	50%	55%
25.	Төгрөг	40%	50%	55%
26.	Цогт	39%	50%	55%
27.	Эрдэнэ	38%	50%	55%
28.	Олонбулаг	29%	50%	55%
	Нэгдсэн гүйцэтгэл	47%	54%	59%

10.1.3. ЭЕШ-ын үзүүлэлт, хүрэх үр дүн

Д/д	Судлагдахуун	ЭЕШ-ын улсын дундаж оноо	ЭЕШ-ын 2015 оны дундаж оноо	ЭЕШ-ын 2016 оны дундаж оноо	Явцын түвшин 2017- 2018 он	Явцын түвшин 2018-2019 он	Хүрэх түвшин 2019- 2020 он
1.	Математик	500	480.6	496	498	500	510
2.	Монгол хэл	500	513.9	524	527	530	540
3.	Нийгэм	500	494.6	512	516	520	530
4.	Англи хэл	500	485.6	475	480	490	500
5.	Орос хэл	511	479.3	456	463	470	500
6.	Газар зүй	500	502.8	511	517	525	530
7.	Физик	500	491.4	490	492	495	500
8.	Хими	500	466.7	488	490	495	500
9.	Биологи	500	462.8	492	495	500	510
10.	МУ-ын түүх	500	502.8	547	550	555	560

11.	Монгол хэл бичиг	499		406	410	420	440
	ЭЭШ-ын Улсад эзэлсэн байр		17-р байр	11-р байр	10-р байр	8-р байр	5-р байр

10.2. Чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлт:

10.2.1. Эцэг эх, олон нийтийн байгууллага нь сургалтын байгууллагатай хамтран ажилласнаар суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гарсан байх 1-ээс доошгүй ажлыг улирал бүр зохион байгуулж хэвшсэн байдал.

10.2.2. Сургууль бүрийн өөрөө удирдах зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон, жилд 1-ээс доошгүй бусдад туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулж, үр дүнд хүрсэн болон чуулганд оролцож урамшуулалд хамрагдсан байдал.

10.2.3. Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх чиглэлээр бусдад туршлага болохуйц шинэлэг ажлуудыг санаачлан зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал.

10.2.4. ЭЭШ-ын чанар, амжилт, ахицын үзүүлэлт.

10.2.5. Сургуулиудын боловсруулсан жишиг даалгаврын уралдаанд оролцсон бүтээлийн амжилт үзүүлэлт.

10.2.6. Ээлжит хичээл бүрд эцэг эхийн төлөөллийг суулгаж, тэмдэглэл хөтөлж хэвшсэн байдал.

10.2.7. Нийт 27 сургуулийн 13 нь ЭКО сургууль болсон. Хөтөлбөрийн хугацаанд бүх сургууль ЭКО, аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.

10.3. Хүлээгдэх үр дүн

10.3.1. Багш нарын заах арга зүй, хүүхэд бүрд хүрч ажиллах, ажлын хариуцлага, ажилдаа хандах хандлага сайжирна.

10.3.2. Хүүхэд бүр үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгосноор сурах хүсэл эрмэлзэл нэмэгдэж сурлагын чанарт ахиц гарна.

10.3.3. Эцэг эхчүүд хүүхдээ сайн хүн болгон төлөвшүүлэхэд өөрсдийнх нь үүрэг, хариуцлага оролцоо чухал үүрэгтэй болохыг ойлгон хүүхдээ сурч хүмүүжихэд нөлөөлөх нөлөөлөл нэмэгдсэн байна.

10.3.4. Сурлагын чанарт ахиц гарч 2015-2016 оны хичээлийн жилийн хөндлөнгийн үнэлгээний үзүүлэлт жил бүр 2-5 хувиар нэмэгдсэн байна.

Арван нэг. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

11.1. Сум бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх салбар хороо, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хичээлийн жилийн хагас жил тутамд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын зөвлөлд тайлагнаж үнэлүүлнэ.

11.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлийн жилийн төгсгөлд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын зөвлөлд тайлагнаж, үнэлүүлэн үр дүнг тооцон ажиллана.

11.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

11.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээллийг Боловсрол, соёл, урлагийн газрын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

11.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг улирал бүр нэгж дээр тайлагнан, салбарын хэмжээнд хагас жил тутамд хэлэлцүүлэн тайлагнаж үнэлүүлнэ.

"Сургалтын чанарыг ахиулах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

д/д	Зорилтын чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Зохион байгуулах ажлын тоо	Нэгж арга хэмжээнд зарцуулагдах төсөв	Төсөв	Эх үүсвэр
Зорилт 1: Суралцагчийн идэвх оролцоог нэмэгдүүлж хөгжил, төлөвшилд зэрэг хандлага бий болгох										
1	1.1 Суралцагчийн идэвх оролцоог нэмэгдүүлж хөгжил, төлөвшилд зэрэг хандлага бий болгоно.	1.1.1 Сурагчдын эрх үүргийг таниулах, хэрэглээ болгох аян зохион байгуулж үйл ажиллагааг хэвшүүлнэ.	Хүүхэд бүр өөрийн сурч хөгжих эрх үүргээ ухамсарлаж, идэвх зүтгэлтэйгээр сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд оролцдог болно	2017	ЕБС	БСУГ	1	-		
2	1.2 Хүүхэд бүрийн өөртөө итгэх итгэл манлайллыг нэмэгдүүлэх	1.2.1 Сургууль бүр сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин, улирал тутам үр дүнг сургууль, эцэг эх, хамт олон, бүсийн хэмжээнд тайлагнана.	"Харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндэлдэг, хариуцлагатай, итгэл даах чадвартай, сурлага болон хүмүүжилд зэрэгээр нөлөөлдөг нөлөөлөл нэмэгдэнэ.	2017-2020 Жил бүрийн 6-р сарын 1	ЕБС	БСУГ, ЕБС, ГБХЗХГ	4	2600	10400.0	ОНТ
3		1.2.2 Сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх 500 хүүхдийн чуулганг аймагт зохион байгуулна.					4	6200	24800.0	ОНХС
Зорилт 2: Суралцагч бүрийн хөгжил төлөвшилд, эцэг эхийн оролцоо хандлагыг нэмэгдүүлэх										
4	2.1 Сургууль, эцэг эх, багш, сурагчдын хамтын ажиллагааг сайжруулна	2.1.1 Сургууль, анги бүхэн сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр эцэг эх, багш, хүүхэд, сургуулийн хооронд дөрөвөлсөн гэрээ байгуулан, төлөвлөгөө боловсруулан ажиллаж улирал тутамд үр дүнгээ тайлагнана.	Эцэг эхийн хандлага өөрчлөгдөж, оролцоо нэмэгдсэнээр сурагчдын сурлагын чанарт ахиц гарна.	2017-2020	ЕБС, эцэг эх	БСУГ	4	1200.0	4800.0	ОНХС
5	2.2 Багш бүрийн зааж буй ээлжит хичээл бүрд эцэг, эхийн төлөөллийг оролцуулж хэвших	2.2.1 Багш бүрийн зааж буй ээлжит хичээл бүрд эцэг, эхийн төлөөллийг суулгаж, ололт, үр дүн, сайжруулах арга замыг улирал бүр тооцож ажиллана.	Багш бүрийн ээлжит хичээлийн бэлтгэл, төлөвлөлт, зааж арга зүй сайжирна. Эцэг эхчүүд хүүхдээ хөгжүүлэх, үнэлэх мэдлэгийг олж авна. Сурагчдын идэвх оролцоо нэмэгдэнэ.	2017-2020	ЕБС	БСУГ				
6		2.2.2 Төрийн болон хувийн хэвшил аж ахуйн нэгж байгууллагууд сургалтын нэг өдөрт оролцож байгаа ажилтнуудаа тухайн өдөр, цагийн ажлаас нь цалинтай чөлөөг олгоно.					Төрийн болон төрийн бус байгууллага	ЕБС	4	-
7	2.3 Төрийн болон төрийн бус байгууллагуудын хүүхдэд ээлтэй үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	2.3.1 "Нэг байгууллага – Нэг бүтээлч ажил" аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж хэвшинэ.	Байгууллага хамт олны хүүхдийн хөгжил төлөвшил, эрүүл мэндэд чиглэсэн олон шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулагдана. Байгууллага бүр өөрийн онцлог давуу талаа таниулах боломж бүрдэнэ.	2017-2020	Төрийн болон төрийн бус байгууллага,	ЕБС, БСУГ	16	-	-	
Зорилт 3-ын хүрээнд: Хүүхэд бүрт ээлтэй сургалтын орчинг бүрдүүлэх										
8	3.1 Хүүхдэд ээлтэй материаллаг орчныг бүрдүүлнэ.	3.1.1 Судлагдахуун бүрээр шилдэг жишиг даалгавар боловсруулах уралдаан зохион байгуулж, эмхэтгэл гарган багш нарт түгээн дэлгэрүүлнэ.	Багш бүр шилдэг санааг тусгасан жишиг даалгавартай болж хүүдийн мэдлэгийг бодитой үнэлэх боломж бүрдэнэ.	2017-2020	ЕБС	БСУГ	4	5500.0	22000.0	ОНХС
9	3.2 Хүүхдэд ээлтэй ЭКО орчин бүрдүүлнэ.	3.2.1 Хүүхдэд ээлтэй ЭКО, аюулгүй орчин бүрдүүлнэ.	Бүх сургууль ЭКО сургууль болж хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлнэ.	2017-2020	ЕБС	БСУГ	-	-	-	-

2022

Зорилт 4-ийн хүрээнд: Сургалтын чанарыг ахиулах, бодитой үнэлэх ахиц амжилт гаргасан баг, хамт олныг урамшуулах ажлыг үе шаттай, үр дүнтэй зохион байгуулах										
10	4.1 Сургалтын чанарыг ахиулах хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулах	4.1.1 Сургалтын чанарыг ахиулах хөндлөнгийн хяналт үнэлгээг жил бүрийн 12-р сарын 2 дахь 7 хоногт зохион байгуулна.	Удирдлагын хариуцлага, хяналтын тогтолцоо, багш нарын идэвх, санаачилга, хандлага, сурагчдын бүтээлчээр бие даан суралцах, эцэг эхийн хүүхдээ хөгжүүлэх, анхаарал тавих үйл ажиллагаа сайжирч сургалтын чанарт ахиц гарна.	2017-2020	ЗДТГ, БСУГ	ЕБС	8	2200.0	17600.0	ОНХС
11		4.1.2 Сургалтын чанарыг ахиулах хөндлөнгийн хяналт үнэлгээг жил бүрийн 5-р сарын 2 дахь 7 хоногт зохион байгуулна.								
12	4.2 ЭЕШ-ын амжилт, чанар үзүүлэлтийг сайжруулах	4.2.1 Аймгийн нутгийн зөвлөл болон боловсролын салбарт амжилттай ажиллаж буй иргэд, компанитай хамтран ЭЕШ-ын намрын их сорилтыг зохион байгуулна.	ЭЕШ-ын бэлтгэгчдэд дадлага болж хичээлээ зөв сонгох, шалтгалтын хугацаагаа зөв тооцоолох, багш нар хүүхдээ цаашид хэрхэн бэлтгэх, амжилттай дүн үзүүлэх зэрэгт тодорхой үр дүн гарна.	2017-2020	БСУГ	ЕБС	4	5000.0	20000.0	Хандив, тусламж
13		4.2.2 ЭЕШ-ын улсын үнэлгээний үзүүлэлтийг сургууль, багш, судлагдахуун бүрээр гаргаж ахиж амжилтыг үнэлнэ.		2017-2020	БСУГ	ЕБС	4	10200.0	40800.0	ОНХС
14	4.3 ЭЕШ болон хөндлөнгийн үнэлгээний үзүүлэлтээр амжилт гаргасан багш, ЗАН, сургуулийн баг хамт олныг үнэлж урамшуулах, хариуцлага тооцох	4.3.1 2 удаагийн хөндлөнгийн үнэлгээний дундаж үзүүлэлтээр 60 хувиас дээш үзүүлэлттэй үнэлэгдсэн ЗАН-ийг урамшуулна.	Ажиллах эрч хүч, урам зориг нэмэгдэнэ	2017-2020	ЗДТГ, БСУГ	ЕБС	4	12000.0	48000.0	ОНХС
15		4.3.2 Шилдэг сургалттай, сурлагын үзүүлэлт сайтай, хөтөлбөрийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн сургууль хамт олны ажлыг бусдад түгээн дэлгэрүүлж, үнэлж, урамшуулна.					4	6000.0	24000.0	ОНХС
16		4.3.3 ЭЕШ-ын намрын сорилго, ЭЕШ-ын улсын үнэлгээний дундаж үзүүлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн судлагдахуун бүрийн эхний 3 багшийг урамшуулна.		2017-2020	ЗДТГ, БСУГ	ЕБС	-	-	-	-
17		4.3.4 Үнэлгээний дундаж гүйцэтгэл 40%-иас доош үнэлэгдсэн, хөтөлбөрт тусгагдсан бусад үйл ажиллагааг хангалтгүй биелүүлсэн багш, ЗАН, сургалтын менежер, захирлуудад тодорхой арга хэмжээ тооцно.		Үүрэг хариуцлагаа ухамсарлан, цаашид ажиллах ажлын эрч хүчээ нэмэгдүүлнэ.	2017-2020	БСУГ	ЕБС	-	-	-
Зорилт 5-ын хүрээнд: Сургуулиудын хэв шинж, менежментийг боловсронгуй болгох										
18	5. Сургуулиудын хэв шинж, менежментийг боловсронгуй болгох	5.1 Есөнбулаг сумын хэмжээнд сургуулийн хэв шинжийг сайжруулж, хамран сургах тойрог болон анги дүүргэлтийн тушаал, журмыг хэрэгжүүлж ажиллана.	Багш, сурагчдын сургалтын чанар сайжирч, хүүхэд бүр ижил тэгш орчинд, нэгдсэн нэг зохион байгуулалт үйл ажиллагаатай болно.	2017-2018	ЗДТГ, БСУГ	ЕБС	-	-	0.0	
19		5.2 Хөдөө орон нутгийн сургуулиудын нөөц боломжид суурилсан бүсийн ахлах сургуулийг бий болгоно.					-	-	0.0	
Хөтөлбөр хэрэгжих 4 жилийн нийт төсөв									212400.0	

Төсвийн эх үүсвэр задаргаа

Нийт	/ Мян.мөг /				
	2017	2018	2019	2020	Нийт
Хандив, тусламж	5000.0	5000.0	5000.0	5000.0	20000.0
Улсын төсөв					0.0
ОНТ	2600.0	2600.0	2600.0	2600.0	10400.0
ОНХС	45500.0	45500.0	45500.0	45500.0	182000.0
Нийт	53100.0	53100.0	53100.0	53100.0	212400.0

420